



## НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

᠒᠐᠒3 оны ᠐᠗ сарын ᠒᠑ өдөр

Дугаар ᠕᠑᠑

Улаанбаатар хот

### А.Минжинсорд асран хамгаалагч тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэр бүлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1, 67 дугаар зүйлийн 67.1.1, 71 дүгээр зүйлийн 71.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрсөн эх нь зуурдаар нас барж асран хамгаалагчгүй, бүтэн өнчирч үлдсэн Багахангай дүүргийн 2 дугаар хороо, Өртөө хэсэг 120 тоотод оршин суух хаягтай, Боржигон овогт Алтанцэцэгийн Минжинсор (РД:УУ17242443)-ын асран хамгаалагчаар түүний нагац эгч болох Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 34 хороо, Шар хад 63 дугаар гудамж 940 тоотод оршин суугч, иргэн Боржигон овогт Энхбаатарын Есүй (РД:УК96041409)-г тогтоосугай.

2.А.Минжинсорд хувийн хэрэг нээж, хяналт тавин ажиллах, холбогдох бичиг баримтыг хууль, журмын дагуу бүрдүүлж иргэн Э.Есүйд хүлээлгэн өгөхийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс (Д.Оюунгэрэл)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД